



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

᠑᠒᠕7 оны ᠐5 сарын 31 өдөр

Дугаар ᠑5

Номгон

“Орон нутгийн өмч-2017” нэгдсэн
арга хэмжээ зохион байгуулах тухай

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалттай холбоотой асуудлаар зарим сум, байгууллагын мэдээллийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх явцад түүнд тавих хяналтын тогтолцоо байхгүй, өмч хөрөнгө эзэнгүйдэх, орон нутгийн өмчид өөриймсөг сэтгэлээр хандах хандлага туйлын хангалтгүй зэрэг нийтлэг дутагдал төрийн болон төсвийн байгууллагуудад гарч байгаад дүгнэлт хийж ажиллах шаардлагатай байгааг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “л” дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчид иж бүрэн тооллого хийж, түүний ашиглалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг цаг тухай бүрт нь хийж хэвшүүлэх, албан тушаалтнууд өөрчлөгдөх тохиолдолд өмч хөрөнгө эзэнгүйдэх, завсардах тохиолдол байгааг таслан зогсоож, хүлээлцүүлж шаардлагатай үед тойрох хуудас зурахгүй буруутай этгээдээр төлүүлсүгэй.

2. Орон нутгийн өмчид бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж орон нутгийн өмч хөрөнгөд тооллого явуулж цэгцлэх зорилгоор “Орон нутгийн өмч-2017” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд батлагдсан удирдамжийн дагуу сум, орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж, байгууллагыг хамруулан зохион байгуулж, шаардагдах төсвийг шийдвэрлэж, дүнг дараа оны 01 дүгээр сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

0117217

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР